



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР  
ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН  
ТУШААЛ

2021 оны 04 сарын 21 өдөр

Дугаар А/76

Улаанбаатар хот

Комисс томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн 3.1 дэх хэсэг, Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нийтлэг дүрмийн 2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн үндэсний төв, түүний харьяа салбар, нэгжид үйлдвэрлэлийн осол, хурц хордлого гарсан тохиолдолд шалтгааныг тогтоох, судлан бүртгэх, акт, дүгнэлт гаргах үүрэг бүхий орон тооны бус байнгын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

Комиссын дарга: Нисэхийн сургалтын төвийн захирал

Нарийн бичгийн дарга: Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан мэргэжилтэн (Галын аюулгүй байдал, гамшгийн асуудал хариуцсан)

Гишүүд: Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлага, дотоод хяналтын албаны аюулгүй ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн

Нислэгийн журам, боловсруулалтын албаны менежер

Нисэхийн сургалтын төвийн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн багшлагч мэргэжилтэн

2. Засгийн газрын 2015 оны 269 дүгээр тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх дүрэм”-ийн дагуу тус байгууллагад гарсан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогыг судлан бүртгэх, акт дүгнэлтийг мэргэжлийн хяналтын байгууллагаар баталгаажуулах, батлагдсан акт дүгнэлтийг үндэслэн нийт ажилтнуудад осол, хурц хордлого гарсан шалтгаан, нөхцөл болон цаашид хэрэгжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар мэдээлэл өгч, сэрэмжлүүлэх арга хэмжээг нэн даруй авах, тухайн алба нэгжид холбогдох шаардлага, зөвлөмж хүргүүлж ажиллахыг Комисст даалгасугай.

2.

3. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хэлтсийн дарга (С.Батхуяг)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.МӨНХЖАРГАЛ